

1998 оны мал тооллого

I. ОРШИЛ

Манай орны эдийн засгийн үндсэн гол салбарын нэг болох хөдөө аж ахуйд нийт ажиллагсадын 47.9 хувь ажиллаж, дотоодын нийт бүтээгдэхүүний 34.6 хувийг үйлдвэрлэж; экспортод хоёрдогч байр суурийг эзлэж байна.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн 80 гаруй хувийг эзэлдэг мал аж ахуйн салбарын хөгжил, түүний бүтээгдэхүүний өсөлтөөс улс орны эдийн засгийн бусад салбар ихээхэн шалтгаалдаг билээ. Нийт малын тоо 1998 оны эцэсд 32.9 саяд хүрч 1997 оныхоос 1.6 сая толгойгоор өслөө.

1998 оны мал тооллоготой хамтруулан малчин өрхийн 5.0 хувь буюу 9.2 мянган өрх, газар тариалан эрхэлдэг 2.0 мянган өрхийн борлуулалтын орлого, бүтээгдэхүүний үнэ, үйлдвэрлэлийн зардалд судалгаа явуулав. Энэ нь улсын хэмжээнд болон аймагт салбарын бүтээгдэхүүний гаргалт, нэмэгдэл өртгийн тооцоонд чухал ач холбогдолтой материал болох юм.

Мал тооллогын бэлтгэл, зохион байгуулалтыг хангуулах, маягт, зааварчилгааг орон нутагт хүргүүлэх, тооллогын маягт, заавар аргачлалд гарсан өөрлөлтийн талаар Үндэсний статистикийн газраас нийт аймаг, нийслэлийн засаг даргын тамгын газар, статистикийн албадад семинар, удирдамж өгч ажиллав.

Дорнод, Дундговь, Говь-Алтай, Хөвсгөл аймагт төвөөс мэргэжлийн хүмүүсийг томилон ажиллуулж, сумдын Засаг даргын орлогч дарга, тооллогын төлөөлөгч нарт мал тооллогыг зохион байгуулах талаар семинар зааварчилга өгүүллээ.

Аймаг, сум, нийслэл, дүүргүүдэд мал тооллогын ажлыг удирдан зохион байгуулж явуулах комисс ажиллуулж, нэгдсэн семинар зөвлөгөөн орон нутагт зохиогдон, тооллогын үеэр сумдад хяналт шалгалтын групп томилон ажиллуулав.

1998 оны мал тооллогын ажлыг зохих заавар журмын дагуу явуулж, мал сүргийг тооллогод бүрэн хамруулах, тооллогын үнэн зөв байдлыг хангуулах талаар аймаг, нийслэлийн Засаг дарга түүний тамгын газраас зориуд анхаарч, дэмжлэг туслалцаа үзүүлэн зохион байгуулсныг тэмдэглэж байна.

II. МАЛ ТЭЖЭЭВЭР АМЬТАДЫН ТОО, БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН

II.1. Малын тоо, бүрэлдэхүүн, тархалт.

Малын тооны өсөлт. 1998 оны эцэст 32.9 сая мал тоологдсон нь 1997 оныхоос 5.1 хувь буюу 1605.2 мянган толгойгоор нэмэгдэж таван төрөл дээрээ өслөө. Урьд оныхоос хонь 528.6 мянга, адуу 165.9 мянга, үхэр 113.0 мянга, ямаа 796.6 мянга, тэмээ 1.2 мянгаар өссөн байна. Малын өсөлтийн 49.6 хувийг ямааны, 32.9 хувийг хонин сүргийн өсөлт хангажээ.

Бодод шилжүүлснээр малын тоо урьд оныхоос 4.4 хувь буюу 468.3 мянгаар өсөв.

Малын тоо (мян.тол)

	1990	1995	1996	1997	1998	1998/1997	
						%	Зөрүү
Бодоор *	9071.5	9868.2	10185.6	10683.2	11151.5	104.4	468.3
Толгойн тоо	25856.9	28572.3	29300.1	31292.3	32897.5	105.1	1605.2
Тэмээ	537.5	367.5	357.9	355.4	356.5	100.3	1.2
Адуу	2262.0	2648.4	2770.5	2893.2	3059.1	105.7	165.9
Үхэр	2848.7	3317.1	3476.3	3612.9	3725.8	103.1	113.0
Хонь	15083.0	13718.6	13560.6	14165.6	14694.2	103.7	528.6
Ямаа	5125.7	8520.7	9134.8	10265.3	11061.9	107.8	796.6

* Бодод шилжүүлэхдээ адуу, үхрийг нэг бод, тэмээг 1.5 бод, 6 хонь, 8 ямааг тус бүр нэг бод гэж тооцов.

19 аймаг урьд онд байсан малаа толгойн дүнгээр өсгөсний дотор 14 аймаг таван төрөл дээр нь өсгөв.

1997 онд 125 сум малаа таван төрөл дээр нь өсгөсөн бол 1998 онд 158 сум малаа төрөл бүр дээр өсгөжээ.

Баян-Өлгий, Ховд аймаг, Улаанбаатар хотын малын тоо 0.1 – 11.4 хувь буюу 0.2 – 173.4 мянган толгойгоор хорогдсон байна.

Тэмээн сүргийн тоо 1990 оноос анх удаа 1998 онд 1.2 мянгаар өссөн байна.

Тэмээний тоо 6 аймагт буурсны дотор Говь-Алтай, Ховд аймагт 1.1-1.6 мянга, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Дундговь аймагт 0.1-0.3 мянгаар буурав. (Хавсралт хүснэгтийн 3, 5-р хуудаснаас үзнэ үү. Цаашид хавсралт хүснэгтийн хуудасны дугаарыг заана)

Сүүлийн жилүүдэд малын тоо толгой нийт дүнгээрээ өсч байгаа боловч төрөл дотроо өсөлт жигд биш байна. Өнгөрсөн найман жил буюу 1991 – 1998 онд манай улсын мал сүргийн тоо 6 жилд нь өсч, 27.2 хувь буюу 7.0 саяаар нэмэгджээ. Энэ өсөлтийн 5.9 сая буюу 84.3 хувийг нь ямаан сүргийн өсөлт эзэллэж байна. 1994 оноос эхлэн ямааны тоо жилд дунджаар 991 мянган толгойгоор өсөх болов.

Сүүлийн 8 жилд малын өсөлтийг төрлөөр үзүүлбэл

	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Өссөн жилийн тоо	6	2	5	5	3	8
Буурсан жилийн тоо	2	6	3	3	5	-
1999 оныхоос өссөн хэмжээ (мян.тол)	7610.4		797.1	877.1		5936.2
1990 оныхоос буурсан хэмжээ (мян.тол)	569.8	181.0			388.8	

Өнгөрсөн найман жилд Өмнөговь, Дундговь, Өвөрхангай, Булган, Баянхонгор аймгийн малын тоо жилд дунджаар 5.2 – 9.5 хувиар өссөн нь бусад аймгуудаас харьцангуй илүүтэй байна. Эдгээр аймгийн ямааны тоо 2.1-3.0 дахин нэмэгдсэн нь нийт малын өсөлтөд голлох үүрэг гүйцэтгэжээ.

Малын өсөлт, бууралтын хувиар аймгуудыг үзүүлбэл :

	1998\1997			
	Бодод шилжүүлснээр		Толгойн тоогоор	
	хувь	зөрүү мян.бод	Хувь	зөрүү мян.тол
Дархан-Уул	119.2	10.1	122.9	31.4
Говьсүмбэр	113.9	5.3	115.2	17.9
Сүхбаатар	111.0	50.7	113.7	155.1
Булган	109.0	49.4	111.4	149.0
Дорнод	109.0	26.0	111.9	78.5
Дундговь	108.7	53.6	109.2	187.1
Хэнтий	108.2	42.3	110.7	134.7
Архангай	107.8	66.2	110.1	195.1
Төв	107.7	59.4	109.3	190.1
Сэлэнгэ	107.6	15.1	109.0	46.9
Өмнөговь	106.7	30.6	106.3	95.4
Өвөрхангай	106.4	56.3	107.5	203.3
Орхон	105.9	2.8	109.9	12.0
Дорноговь	104.7	16.5	105.7	54.7
Хөвсгөл	104.6	41.3	106.7	143.5
Баянхонгор	103.2	22.0	103.4	83.4
Увс	102.7	15.5	104.5	83.7
Завхан	100.6	5.1	101.8	47.1
Говь-Алтай	99.6	-2.2	100.0	0.6
Улаанбаатар	98.0	-2.3	99.9	-0.2
Ховд	91.6	-46.5	93.2	-130.6
Баян-Өлгий	88.5	-48.8	88.6	-173.4

Манай орны түүхэнд 1998 онд хамгийн олон мал, үүний дотор хамгийн олон адуу, үхэр, ямаа тоологдов.

Малын тоо толгойн хүрсэн дээд хэмжээг үзүүлбэл:

	1918 оноос хойш		Жилийн эцэст тоолдог болсон 1961 оноос хойш	
	мян.тол	он	мян.тол	он
Бүгд	32897.5	1998	32897.5	1998
Тэмээ	895.3	1954	751.7	1961
Адуу	3059.1	1998	3059.1	1998
Үхэр	3725.8	1998	3725.8	1998
Хонь	15936.4	1941	15083.0	1990
Ямаа	11061.9	1998	11061.9	1998

1990 оноос хойш нийт сүрэгт тэмээ, хонины эзлэх хувийн жин жилээс жилд буурч байна.

Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувь

	1990	1993	1994	1995	1996	1997	1998
Тэмээ	2.1	1.5	1.4	1.3	1.2	1.1	1.1
Адуу	8.8	8.7	9.0	9.3	9.4	9.3	9.3
Үхэр	11.0	10.8	11.2	11.6	11.9	11.5	11.3
Хонь	58.3	54.7	51.4	48.0	46.3	45.3	44.7
Ямаа	19.8	24.3	27.0	29.8	31.2	32.8	33.6
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

Улсад нийт малын тоогоор Өвөрхангай, тэмээгээр Өмнөговь, адуугаар Төв, үхрээр Хөвсгөл, хониор Өвөрхангай, ямаагаар Баянхонгор тэргүүн байранд байна. (Хавсралтын хуудасны дугаар 1)

Манай улс дэлхийн улс орнуудын дотор адуугаар 6 дугаар, тэмээгээр 12, ямаагаар 11, хониор 19, үхрээр 54 дугаар байранд орж байна.

Ази тивд адуугаар 2 дугаар, тэмээгээр 4, хониор 6, ямаагаар 7, үхрээр 14 дугаар байранд орж байна.

Адуу, тэмээ, ямааны тоогоор (мян.тол)

Улсын нэр	Адууны тоо	Улсын нэр	Тэмээний тоо	Улсын нэр	Ямааны тоо
1.Хятад	10194	1.Сомали	6100	1.Хятад	170993
2.Бразил	6394	2.Судан	2950	2.Энэтхэг	120600
3.Мексик	6250	3.Энэтхэг	1520	3.Пакистан	47000
4.АНУ	6150	4.Мавритан	1182	4.Бангладеш	34478
5.Аргентин	3300	5. Пакистан	1100	5.Иран	26000
6.Монгол	3059	6.Этиоп	1030	6.Нигери	24500
7.Колумби	2450	7.Кени	810	7.Судан	16900
8.Орос	2300	8.Чад	677	8.Этиоп	16850
9.Казахстан	1312	9.Саудын	422	9.Индонези	14400

		араб			
		10.Нигер	392	10.Сомали	12500
		11.Мали	365	11.Монгол	11062
		12.Монгол	356	12.Мексик	10500

Тайлбар: Дэлхийн улсуудын малын тоог 1997 оноор авсан болно.

Манай улс дэлхийд нэг хүн амд ногдох адуу, ямаагаар тэргүүн байр, тэмээгээр 3, хониор 4-р байранд тус тус орж байна.

Нэг хүн амд ногдох малын тоогоор эхний байруудад ордог улс орнуудыг үзүүлбэл: (толгой)

Адуугаар		Тэмээгээр		Хониор		Ямаагаар	
1.Монгол	1.21	Сомали	0.60	Шинэ зела	13.02	Монгол	4.30
2.Аргентин	0.09	Мавритан	0.49	Австрали	6.76	Мавритан	1.73
3.Казахстан	0.08	Монгол	0.15	Уругвай	6.14	Сомали	1.22
4.Мексик	0.07	Судан	0.11	Монгол	5.93	Мали	0.74
5.Колумби	0.07	Чад	0.10	Судан	0.84	Судан	0.61

Хувийн (амины) малын тоо. 1998 онд улсын хэмжээгээр аминдаа малтай 275.0 мянган өрх тоологдсоны дотор 68.1 хувь буюу 187.1 мянга нь малчин өрх, 31.9 хувь буюу 87.8 мянга нь мал бүхий бусад иргэдийн өрх байна. Хувийн малын тоо 1990 онд нийт малын 31.9 хувь байснаа 1998 онд 95.3 хувийг эзлэх болов. Хувийн малын тоо 31.4 саяд хүрч, өмнөх оныхоос 1.8 сая толгойгоор нэмэгдэв.

Ямаа, адууны 97.5 хувь, тэмээ, үхрийн 97.0 – 97.2 хувь, хонины 92.8 хувь нь хувийн аж ахуйд ногдох болжээ.

Өнгөрсөн онд Баян-Өлгий, Ховд аймгаас бусад аймаг, хотын малын тоо урьд оныхоос өссөн байна.

Хувийн малын өсөлт, аймгаар (мян.тол)

	Толгойн тоо (мян.тол)					1998\1997	
	1990	1995	1996	1997	1998	хувь	Зөрүү
Архангай	565.4	1577.9	1697.8	1900.8	2096.7	110.3	195.9
Баян-Өлгий	607.6	1324.6	1381.3	1494.7	1330.7	89.0	-164.0
Баянхонгор	505.1	2134.8	2155.2	2359.3	2477.0	105.0	117.7
Булган	273.7	1018.6	1096.5	1210.0	1382.0	114.2	171.9
Говь-Алтай	525.8	2044.3	2038.7	2070.7	2077.7	100.3	7.0
Дорноговь	269.9	776.5	817.2	867.4	926.4	106.8	59.1
Дорнод	169.4	466.9	483.8	549.6	636.8	115.9	87.3
Дундговь	438.6	1660.8	1790.0	1970.5	2157.8	109.5	187.3
Завхан	676.4	2330.4	2408.3	2505.6	2560.1	102.2	54.5
Өвөрхангай	801.4	2465.3	2427.5	2611.8	2829.8	108.3	217.9
Өмнөговь	303.8	1159.6	1275.0	1458.5	1555.6	106.7	97.1
Сүхбаатар	286.8	894.8	937.8	1042.5	1209.6	116.0	167.2
Сэлэнгэ	123.1	314.0	331.4	371.1	442.4	119.2	71.3
Төв	512.3	1420.8	1553.1	1747.2	1968.8	112.7	221.7
Увс	550.1	1657.0	1679.5	1780.7	1880.7	105.6	100.0
Ховд	584.0	1944.5	1842.3	1845.0	1728.4	93.7	-116.6

Хөвсгөл	605.9	1789.1	1923.6	2102.1	2246.5	106.9	144.4
Хэнтий	308.8	959.7	1004.4	1103.3	1231.0	111.6	127.7
Дархан-Уул	38.0	102.4	102.8	103.8	139.3	134.3	35.6
Улаанбаатар	77.5	250.2	254.7	256.0	268.2	104.8	12.1
Орхон	19.3	95.4	96.7	99.3	113.8	114.6	14.5
Говьсүмбэр	-	59.6	67.6	79.1	96.9	122.5	17.8
ДҮН	8242.9	26447.2	27365.2	29529.0	31356.3	106.2	1827.3

Хувийн аж ахуйд байгаа малын бүтцийг авч үзвэл хонь 43.5 хувь, ямаа 34.4, үхэр 11.5, адуу 9.5, тэмээ 1.1 хувийг эзлэж байна.

Хувийн аж ахуйн мал, төрлөөр (мян.тол)

	Малтай өрхийн тоо	Бүгд	Ү Ү Н Э Э С				
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
1990	262.3	8242.9	88.2	1108.1	1457.5	3684.7	1904.4
1991	288.9	14002.6	186.3	1492.1	1896.6	7209.4	3218.2
1992	301.5	18081.1	253.7	1728.0	2237.4	9589.1	4272.9
1993	289.7	22565.2	335.0	2026.8	2503.5	11902.0	5797.9
1994	289.2	24527.2	343.3	2279.0	2811.8	12133.8	6959.3
1995	283.9	26447.2	349.7	2532.0	3140.4	12194.1	8231.0
1996	278.3	27365.2	342.6	2670.6	3323.4	12184.6	8844.0
1997	279.7	29529.0	343.8	2807.4	3485.3	12912.0	9980.5
1998	275.0	31356.3	346.4	2982.6	3613.5	13630.1	10783.8

Иргэдийн хувийн малын бүлэглэлтээс үзвэл 51-200 малтай өрх бусад бүлгээс харьцангуй олонхи нь буюу 47.4 хувийг эзлэж байна.

1997 онд 50 хүртэл малтай өрх нийт мал бүхий өрхийн 39.8 хувийг эзлэж байсан бол 1998 онд 37.2 хувь болж буурлаа. Энэ хугацаанд 51-1000 малтай өрхийн эзлэх хувийн жин 2.5 пунктээр нэмэгдсэн байна. 1000 ба дээш малтай өрх 1997 онд 599 байсан бол 1998 онд 955 болж 1.6 дахин нэмэгджээ.

Иргэдийн хувийн малын бүлэглэлт (мал-мян.тол)

	Малтай өрхийн тоо		Дүнд эзлэх хувь		Малын тоо	
	1997	1998	1997	1998	1997	1998
10хүртэл малтай	35530	31668	12.5	11.5	200.9	170.5
11-30 малтай	41009	36837	14.7	13.4	832.1	758.0
31-50 малтай	34784	33733	12.4	12.3	1409.5	1382.2
51-100 малтай	63774	62941	22.8	22.9	4796.6	4731.9
101-200 малтай	65282	67466	23.3	24.5	9085.7	9469.1
201-500 малтай	34539	36275	12.4	13.2	9855.3	10496.1
501-999 малтай	4137	5112	1.5	1.9	2632.1	3205.0
1000-1499 малтай	531	860	0.2	0.3	574.7	967.3
1500-2000 малтай	54	62	0.0	0.0	89.7	101.4

2001-ээс дээш малтай	14	33	0.0	0.0	32.2	74.4
ДҮН	279654	274987	100.0	100.0	29529.0	31355.9

Одоо 50 хүртэл малтай өрхүүд үндсэндээ дөрвөн хошуу малтай байгаагийн дотор 10 хүртэл малтай өрх дунджаар 1 адуу, 3 үхэр, 2 бог малтай байна.

Нэг өрхөд ногдох хувийн малын бүлэглэлт 1998 оны байдлаар (толгой)

	Бүгд	Ү Ү Н Э Э С				
		тэмээ	адуу	үхэр	хонь	цмаа
10хүртэл малтай	5.4	0.0	0.7	3.0	0.9	0.9
11-30 малтай	20.6	0.1	2.8	6.2	5.7	5.9
31-50 малтай	41.0	0.2	4.9	9.0	14.1	12.8
51-100 малтай	75.2	0.5	8.3	11.9	28.9	25.6
101-200 малтай	140.4	1.4	13.3	15.8	60.2	49.7
201-500 малтай	289.3	4.3	25.3	23.9	131.1	104.7
501-999 малтай	627.0	9.8	52.5	44.7	318.8	201.2
1000-1499 малтай	1124.7	12.5	88.7	76.1	627.4	320.0
1500-2000 малтай	1635.0	14.1	124.8	101.5	971.2	423.4
2001-с дээш малтай	2253.4	17.7	152.1	128.3	1528.4	426.9
ДҮН	114.0	1.3	10.5	13.1	49.6	39.2

Улсын дунджаар малтай нэг өрхөд (бодод шилжүүлснээр) 39 бод буюу 114 толгой мал ногдож байхад Булган, Говь-Алтай, Дорноговь, Дундговь, Завхан, Өмнөговь, Сүхбаатар аймагт 40-62 бод буюу 119-204 толгой мал ногдож байна.

Малтай нэг өрхөд ногдох хувийн малын тоо

	Бодод шилжүүлснээр			Толгойн тоогоор		
	1996	1997	1998	1996	1997	1998
Архангай	34.9	37.8	41.1	77	85	95
Баян-Өлгий	27.2	28.4	24.8	95	101	88
Баянхонгор	37.1	39.1	41.3	127	137	145
Булган	41.0	43.4	49.6	93	101	119
Говь-Алтай	41.1	39.5	40.1	162	161	164
Дорноговь	47.7	51.0	54.1	129	140	149
Дорнод	27.2	28.0	34.1	57	60	76
Дундговь	55.3	59.1	61.9	179	194	204

Завхан	41.9	43.0	44.5	129	133	140
Өвөрхангай	35.5	36.5	39.5	105	111	122
Өмнөговь	49.1	53.2	57.3	155	174	187
Сүхбаатар	39.4	42.3	47.3	95	103	119
Сэлэнгэ	12.9	14.0	16.5	30	34	42
Төв	34.1	37.4	42.0	84	95	109
Увс	29.9	31.2	33.2	93	100	108
Ховд	38.0	36.8	35.6	127	126	124
Хөвсгөл	35.8	37.8	39.4	83	90	96
Хэнтий	37.1	40.3	46.0	84	92	109
Дархан-Уул	10.4	10.4	10.9	24	25	28
Улаанбаатар	11.2	11.5	12.9	26	28	33
Орхон	14.5	17.3	21.9	33	42	56
Говьсүмбэр	22.3	25.5	30.9	58	67	85
ДҮН	34.7	36.5	39.0	98	106	114

Хээлтэгч мал. 1998 оны эцэст 13925.5 мянган хээлтэгч мал тоологдсон нь өмнөх оныхоос 830.0 мянгаар өссөний дотор ямаа 417.1 мянга, эм хонь 297.3, гүү 53.5 мянга, үнээ 62.0 мянга, ингэ 0.2 мянгаар өссөн байна.

Хээлтэгч малын тоо (мян.тол)

	1990	1995	1996	1997	1998	1998\1997	
						Хувь	Зөрүү
Ингэ	140.9	101.3	98.7	97.7	97.9	100.2	0.2
Гүү	563.5	707.1	737.0	783.2	836.6	106.8	53.5
Үнээ	1127.1	1177.8	1215.4	1370.8	1432.8	104.5	62.0
Эм хонь	7786.1	5948.3	5844.1	6370.6	6667.9	104.7	297.3
Эм ямаа	2425.7	3607.7	3876.6	4473.2	4890.3	109.3	417.1
ДҮН	12043.3	11542.2	11771.8	13095.5	13925.5	106.3	830.0

Баян-Өлгий, Говь-Алтай, Ховд аймаг, нийслэл хотоос бусад аймаг хээлтэгч малынхаа тоог урьд оныхоос өсгөсөн байна. (Хавсралтын хуудасны дугаар 15 – 16)

1961 оноос хойш хамгийн олон хээлтэгч мал тоологдсон жил

	мян.тол	Он		мян.тол	Он
Ингэ	226.9	1961	Эм хонь	7786.1	1990
Гүү	836.6	1998	Эм ямаа	4890.3	1998
Үнээ	1432.8	1998			

Төл бойжилт. 1998 онд гарсан төлийн 90.4 хувь буюу 9907.3 мянган төл бойжуулав. Бойжсон төлийн тоо өмнөх оныхоос 489.8 мянгаар нэмэгджээ. Бойжуулсан нийт төлөөс 4.9 мянгыг каракуль арьсанд нядалсан байна.

Төл бойжилт (мян.тол)

	Бүгд	Ү Ү Н Э Э С					1998\1997 зөрүү
		Ботго	унага	Тугал	хурга	ишиг	
Гарсан	10956.0	42.7	558.1	1038.8	5547.8	3768.8	872..6
Бойжсон	9907.3	38.4	516.5	980	5094.5	3277.9	370.0
Хорогдсон	1048.7	4.3	41.6	58.6	453.3	490.9	502.6
Бойжилтын хувь	90.4	89.9	92.5	94.4	91.8	87.0	

Бойжуулсан төл (мян.тол)

	1991- 1995 оны дундаж	1993	1994	1995	1996	1997	1998
Ботго	42.3	35.6	36.7	40.5	37.0	39.3	38.4
Унага	357.4	289.8	387.6	451.2	467.2	471.9	516.5
Тугал	778.1	669.3	812.9	920.4	918.1	944.6	980.0
Хурга	5431.3	4906.6	5085.2	4969.2	4873.3	4946.4	5094.5
Ишиг	2141.5	1860.5	2307.6	2631.1	2751.9	3135.1	3277.9
Бүгд	8750.6	7761.8	8630.0	9012.4	9047.5	9537.3	9907.3

1998 онд хамгийн олон ишиг, тугал, унага бойжуулан авлаа.

1961 оноос хойш хамгийн олон төл бойжуулсан жил

	мян.төл	он		мян.төл	он
Бүгд	9907.3	1998	Тугал	980.0	1998
Ботго	74.4	1975	Хурга	6569.6	1989
Унага	516.5	1998	Ишиг	3277.9	1998

1999 онд 100 эхээс бойжуулсан төлийг өмнөх оныхтой зэрэгцүүлж үзвэл унага 2-оор их, ботго 1, тугал 7, хурга 5, ишиг 8-аар бага байна.

100 эхээс бойжуулсан төл

	1991-1995 оны дундаж	1993	1994	1995	1996	1997	1998
Ботго	36	32	37	40	37	40	39
Унага	61	51	67	69	66	64	66
Тугал	72	65	78	79	78	78	72
Хурга	77	69	79	79	82	85	80
Ишиг	78	70	80	80	76	81	73
Бүгд	76	68	78	78	78	81	76

100 хээлтэгчээс Архангай, Өвөрхангай, Булган, Дундговь, Дорнод, Сүхбаатар, Орхон, Хөвсгөл, Завхан, Хэнтий, Дархан-Уул, Говьсүмбэр аймаг 80-88 төл бойжуулсан байхад Ховд, Баян-Өлгий, Говь-Алтай

аймаг, Улаанбаатар хот 58-66 төл бойжуулжээ. (Хавсралтын хуудасны дугаар 18)

Том малын зүй бус хорогдол. 1998 оны эхний малын 2.5 хувьтай тэнцэх 785.7 мянган том мал зүй бусаар хорогдсон нь урьд оныхоос 168.0 мянгаар их, 1991-1995 оны дунджаас 187.3 мянгаар бага байна.

Том малын зүй бус хорогдол

	1991-1995 оны дундаж	1991	1994	1995	1996	1997	1998
Тэмээ	16.6	20.8	9.5	7.5	8.4	6.0	6.3
Адуу	76.7	72.7	41.6	48.1	53.2	45.1	50.7
Үхэр	132.9	104.6	78.3	84.6	79.8	110.6	111.4
Хонь	579.1	624.1	423.8	403.2	288.7	278.9	344.2
Ямаа	167.7	156.0	136.8	130.5	156.7	177.1	273.0
Бүгд	973.0	978.2	690.0	673.9	586.8	617.7	785.7

Оны эхний малд зүй бус хорогдолын эзлэх хувь

	1991-1995 оны дундаж	1991	1994	1995	1996	1997	1998
Тэмээ	3.7	3.9	2.6	2.0	2.3	1.7	1.8
Адуу	3.4	3.2	1.9	2.0	2.0	1.6	1.8
Үхэр	4.7	3.7	2.9	2.8	2.4	3.2	3.1
Хонь	4.0	4.1	3.1	2.9	2.1	2.1	2.4
Ямаа	2.9	3.0	2.2	1.8	1.8	1.9	2.7
Бүгд	3.8	3.8	2.7	2.5	2.1	2.1	2.5

1997-1998 оны өвөл, хавар зарим сумдын бэлчээрийн хомсдолоос шалтгаалан Ховд, Баян-Өлгий, Говь-Алтай аймгийн дүнгээр 399.3 мянган том мал зүй бусаар хорогдсон нь улсын хэмжээний нийт хорогдолын 50.8 хувийг эзлэж байна. (Хавсралтын хуудасны дугаар 19)

Том малын зүй бус хорогдлын 24.7 хувь буюу 193.7 мянга нь өвчнөөр, 34.8 хувь буюу 273.6 мянга нь гэнэтийн аюулаар хорогдов.

1961 оноос хойш малын зүй бус хорогдол хамгийн бага болон их гарсан жил

	Хамгийн бага хорогдол гарсан		Хамгийн их хорогдол гарсан	
	мян.тол	Он	мян.тол	Он
Бүгд	510.3	1989	2663.8	1968
Тэмээ	6.0	1997	66.3	1966
Адуу	41.6	1994	235.3	1968
Үхэр	52.3	1974	278.9	1993
Хонь	278.9	1997	1606.3	1968
Ямаа	89.3	1989	574.8	1968

Малын хээл хаялт, сувайралт. 1998 оны хээлтэгч малын 11.5 хувь буюу 1500.0 мянга нь хээл хаяж, сувайрсан нь 1991-1995 оны дунджаас 2.8 хувь буюу 43.4 мянга, өмнөх оныхоос 5.2 хувь буюу 82.7 мянгаар буурсан байна.

Говь-Алтай, Өмнөговь, Сэлэнгэ, Ховд, Хөвсгөл аймаг оны эхний хээлтэгч малынхаа 14.3-22.1 хувиас дээрх шалтгаанаар төл авч чадсангүй.
(Хавсралтын хуудасны дугаар 20-22)

Говь-Алтай, Өмнөговь, Сэлэнгэ, Ховд аймгууд 1998 онд 100 эхээс улсын дунджаас 6-17 толгойгоор бага төл бойжуулсан нь хээл хаялт, сувайралт их гарснаас голлон шалтгаалсан байна.

Хээл хаяж, сувайрсан эх малын тоо (мян.тол)

	Төл өгөөгүй хээлтэгч мал бүгд				үүнээс сувайрсан		
	1991-1995 дундаж	1997	1998	1998\1997 хувь	1990-1995 дундаж	1997	1998
Ингэ	14.1	11.1	8.5	76.6	11.3	8.3	7.0
Гүү	182.1	219.6	180.2	82.1	138.7	159.0	125.6
Үнээ	236.3	223.5	246.3	110.2	189.0	170.6	184.3
Эм хонь	767.0	604.5	518.4	85.8	538.6	406.0	352.5
Эм ямаа	343.9	524.0	546.5	104.3	205.8	298.7	298.3
ДҮН	1543.4	1582.7	1500.0	94.8	1083.4	1042.6	967.8

Нийт хээлтэгчид хээл хаяж, сувайрсан эх малын эзлэх хувь

	Бүгд			үүнээс сувайрсан		
	1991-1995	1997	1998	1991-1995	1997	1998
Ингэ	12.1	11.2	8.7	9.7	8.4	7.1
Гүү	31.3	29.8	23.0	23.8	21.6	16.0
Үнээ	21.8	18.4	18.0	17.4	14.0	13.4
Эм хонь	10.9	10.3	8.1	7.7	6.9	5.5
Эм ямаа	12.7	13.5	12.2	7.6	7.7	6.7
ДҮН	13.4	13.4	11.5	9.3	8.9	7.4

1961 оноос хойш эх малын хээл хаялт, сувайралт хамгийн бага болон их гарсан жил

	Хамгийн бага		Хамгийн их	
	мян.тол	он	мян.тол	Он
Бүгд	645.8	1963	1907.9	1977
Ингэ	8.5	1998	26.4	1973
Гүү	152.3	1995	333.6	1973
Үнээ	106.1	1962	326.0	1981
Эм хонь	190.6	1962	913.0	1993
Эм ямаа	124.7	1963	558.1	1968

Хээлтээгч, хээлтүүлэгчийн тохироо. Үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 25-30 хээлтэгч ногдох ёстой байхад одоо улсын дунджаар 63 эм хонь, 62 эм ямаа ногдож, хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо алдагдсан хэвээр байна. Энэ байдал эх малын сувайралт нэмэгдүүлэхэд нөлөөлж, мал өсгөх багагүй нөөц бололцоог алдаж байна.

1990 онд улсын хэмжээгээр 7786.1 мянган эм хонь байхад үржлийн ажилд 242.7 мянган хуц ашиглагдаж байсан бол 1998 онд 6667.9 мянган эм хонинд 106.1 мянган хуцтай байна. 1990 онд 20.9 мянган хуц шинээр нэмж тавьж байсан бол 1997-1998 онд 3.1-5.5 мянгыг шинээр тавьжээ.

Хээлтүүлэгч малын тоо (мян.тол)

	Бүгд				үүнээс: шинээр тавьсан		
	1990	1997	1998	1998\1997	1990	1997	1998
Буур	4.1	4.8	4.8	100.0	66.0	54.0	0.1
Азрага	70.5	112.3	119.4	106.3	0.9	1.2	1.7
Бух	59.5	60.3	60.7	100.7	2.5	1.3	1.7
Хуц	242.9	104.2	106.1	101.8	20.9	2.5	5.5
Ухна	73.6	75.3	79.1	105.0	7.5	1.5	3.6
ДҮН	450.6	356.9	370.1	103.7	31.9	6.6	12.6

Нэг хээлтүүлэгчид ногдох хээлтэгч малын тоо

	Үржлийн норм	1990	1995	1996	1997	1998
Ингэ	20-25	34	21	21	20	21
Гүү	12-15	8	7	7	7	7
Үнээ	35-45	19	20	21	23	22
Эм хонь	25-30	32	57	57	61	63
Эм ямаа	25-30	33	53	54	59	62

Говь-Алтай, Архангай, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл аймагт хуц, Говь-Алтай, Ховд, Баянхонгор, Хөвсгөл аймагт ухна их дутагдалтай байна.(Хавсралтын хуудасны дугаар 25)

Малын хэрэглээний зарлага. Оны эхны нийт малын 24.0 хувьтай тэнцэх 7511.4 мянган малыг хүнсний хэрэгцээнд зарцуулсан нь 1997 оныхоос 591.4 мянган толгойгоор нэмэгдсэн байна. (Хавсралтын хуудасны дугаар 23)

1998 онд оны эхний тэмээний 8.7 хувь, адууны 10.4 хувь, үхрийн 20.9 хувь, хонины 29.8 хувь, ямааны 21.5 хувийг хүнсний хэрэглээнд зарцуулжээ.

Тэмээний хэрэглээ 1998 онд буурснаас тоо толгой нь ялимгүй өслөө. Тэмээний хүнсний хэрэглээг уламжилт хэрэглээний хэмжээнд нь ойртуулж 7-8 хувиас хэтрүүлэхгүй байлгах шаардлагатай байна. Говийн бүсийн аймгуудад тэмээний махны хэрэглээг ямааны махаар нөхөх боломж ихтэй болов. Тэмээ их хорогдож байгаа Говь-Алтай, Ховд аймагт оны эхэнд байсан тэмээнийхээ 9.7 хувийг хүнсэнд хэрэглэсэн байхад ямааны хувьд 16.3-26.2 хувийг л хэрэглэжээ. (Хавсралт хуудасны дугаар 24)

Малын нийт хэрэглээний зарлага. (мян.тол)

	1986-1990 оны дундаж	1991-1995 оны дундаж	1991	1995	1996	1997	1998
Бүгд	7559.8	7219.3	8930.5	6567.3	7726.3	6920.0	7511.4
Тэмээ	38.9	59.4	93.6	31.6	38.3	35.8	30.8
Адуу	201.7	203.5	273.8	163.5	291.9	304.1	299.8
Үхэр	544.3	551.5	684.6	523.9	679.0	697.4	755.6
Хонь	5311.3	5110.1	6174.6	4627.1	4736.0	4055.1	4216.7
Ямаа	1463.6	1294.8	1703.9	1221.2	1981.1	1827.6	2208.3

Оны эхний малд эзлэх хувь

	1986-1990 оны дундаж	1991-1995 оны дундаж	1991	1995	1996	1997	1998
Бүгд	32.7	28.2	34.5	25.5	27.0	23.6	24.0
Тэмээ	7.0	13.2	17.4	8.6	10.4	10.0	8.7
Адуу	9.8	9.0	12.1	6.8	11.0	11.0	10.4
Үхэр	21.5	19.4	24.0	17.4	20.5	20.1	20.9
Хонь	39.4	35.4	40.9	33.6	34.5	29.9	29.8
Ямаа	32.5	22.7	33.2	16.9	23.3	20.0	21.5

Сүргийн бүтэц. Нийт сүргийн 33.9 хувь нь төл, өсвөр насны, 42.0 хувь нь хээлтэгч, 22.6 хувь нь нас гүйцсэн эр мал, 1.1 хувь нь хээлтүүлэгч мал байна.

Сүрэгт хээлтэгчийн эзлэх хувь урьд оныхоос 0.1 пунктаар өссөний дотор үнээнээс бусад эх малын хувийн жин нэмэгдэв.

Сүргийн бүтэц (хувиар)

	Төл, өсвөр насны			Нас гүйцсэн эр		
	1990	1997	1998	1990	1997	1998
Тэмээ	32.7	30.0	30.3	36.1	41.1	40.9
Адуу	37.6	36.1	36.5	34.4	33.0	32.3
Үхэр	49.8	44.9	44.8	8.5	15.5	15.1
Хонь	38.4	33.9	34.1	8.5	20.4	19.8
Ямаа	35.2	29.9	29.3	16.2	25.8	20.4
ДҮН	38.8	34.0	33.9	13.0	23.0	22.6

үргэлжлэл

	Хээлтэгч			Хээлтүүлэгч		
	1990	1997	1998	1990	1997	1998
Тэмээ	26.2	27.5	27.5	0.8	1.4	1.3
Адуу	24.9	27.1	27.3	3.1	3.9	3.9
Үхэр	39.6	37.9	35.4	2.1	1.7	1.6
Хонь	51.6	45.0	45.4	1.5	0.7	0.7
Ямаа	47.3	43.6	44.2	1.3	0.7	0.7
ДҮН	46.6	41.9	42.0	1.6	1.1	1.1

Сүүлийн жилүүдэд сүргийн дотоод бүтцэд томоохон өөрчлөлт гарлаа. 1998 онд нас гүйцсэн эр малын тоо 7.4 сая толгойд хүрсэн нь 1990 оныхоос 2.2 дахин буюу 4.1 сая толгойгоор өссөн байна.

Энэ хугацаанд эр ямааны тоо 3.4 дахин, эр үхэр, хонины тоо 2.3 дахин нэмэгдэж, нийт сүрэгт 8.5-16.2 хувийг эзлэж байсан бол 15.1-20.4 хувийг эзлэх болов.

Нас гүйцсэн эр малын тоо (мян.тол)

	1990	1996	1997	1998	1999\1998	
					хувь	зөрүү
Ат	193.8	149.6	146.2	145.8	75.2	-48.0
Морь	778.2	922.3	954.2	986.9	126.8	208.7
Шар	243.4	402.4	558.4	562.5	231.1	319.1
Эр хонь	1286.4	2998.9	2886.8	2904.8	225.8	1618.4
Эр ямаа	831.8	2556.8	2645.2	2849.2	342.5	2017.4
ДҮН	3333.6	7030.0	7190.8	7449.3	223.5	4115.7

Цэвэр үүлдрийн болон эрлийз, нутгийн шилдэг омгийн мал. 1998 оны эцэст цэвэр үүлдрийн 762.8 мянга, эрлийз 1128.6 мянга, нутгийн шилдэг омгийн 698.0 мянган мал тоологдов. Цэвэр үүлдрийн мал 1997 оныхоос 1.2 хувь буюу 90.2 мянга, эрлийз 2.9 хувь буюу 31.8 мянгаар нэмэгдлээ.

(Хавсралт хуудасны дугаар 25,26)

1998 онд тоологдсон нийт үхрийн 4.3 хувь, хонины 9.8 хувь, ямааны 2.7 хувийг цэвэр, эрлийз мал эзлэж байна. Нийт цэвэр, эрлийз малын 91.3 хувь хувийн аж ахуйд, 8.7 хувь нь хөдөө аж ахуйн компани, хоршоо, улсын үйлдвэрийн газар, бусад байгууллагад ногдож байна.

Нутгийн шилдэг омгийн 1.4 мянган тэмээ, 16.8 мянган адуу, 5.9 мянган үхэр, 467.4 мянган хонь, 206.5 мянган ямаа тоологдлоо.

Цэвэр үүлдрийн болон эрлийз, нутгийн шилдэг омгийн
малын тоо, төрлөөр (мян.тол)

	1994	1996	1997	1998	1998\1997	
					хувь	зөрүү
1.Цэвэр үүлдрийн бүх мал	338.6	737.0	753.6	762.8	101.2	9.2
үхэр	39.3	53.5	50.2	39.8	79.3	-10.4
хонь	226.6	608.1	612.0	638.8	104.4	26.8
ямаа	72.7	75.4	91.4	84.2	92.1	-7.2
2. Эрлийз	583.0	960.7	1096.8	1128.6	102.9	31.8
үхэр	94.4	115.9	125.7	119.2	94.8	-6.5
хонь	348.9	654.7	751.2	795.0	105.8	43.8
ямаа	139.7	190.1	219.9	214.4	97.5	-5.5
3.Нутгийн шилдэг омгийн	846.1	695.0	762.7	698.0	91.5	-64.7
үхэр	25.5	3.3	3.9	5.9	151.3	2.0
хонь	770.0	555.0	568.0	467.4	82.3	-100.6
ямаа	50.6	124.9	180.2	206.5	114.6	26.3
тэмээ		4.3	2.9	1.4	48.3	-1.5
адуу		7.5	7.7	16.8	218.2	9.1

Цэвэр үүлдэр, эрлийз малын тоо, аж ахуйн салбараар. (мян.тол)

	Нийт цэвэр эрлийз мал		Үхэр		Хонь		Ямаа	
	1997	1998	1997	1998	1997	1998	1997	1998
Хувийн аж ахуй	1615.6	1727.4	138.4	130.4	1171.4	1314.4	305.8	282.6
Бусад	234.8	163.9	37.5	28.5	191.8	119.4	5.5	16.0
ДҮН	1850.4	1891.3	175.9	158.9	1363.2	1433.8	311.3	298.6
Салбаруудын эзлэх хувийн жин								
Хувийн аж ахуй	87.3	91.3	78.7	82.1	85.9	91.7	98.2	94.6
Бусад	12.7	8.7	21.3	17.9	14.1	8.3	1.8	5.4
Дүн	100	100.0	100	100.0	100	100.0	100	100.0

Нийт малд цэвэр үүлдрийн болон эрлийз малын эзлэх хувь

	Үхэр		Хонь		Ямаа	
	1997	1998	1997	1998	1997	1998
Бүгд	4.9	4.3	9.6	9.8	3.0	2.7
цэвэр	1.4	1.1	4.3	4.3	0.9	0.8
эрлийз	3.5	3.2	5.3	5.4	2.1	1.9
Хувийн аж ахуй	4.0	3.5	9.1	8.9	3.1	2.6
цэвэр	0.8	0.6	3.8	3.8	0.9	0.7
эрлийз	3.2	2.9	5.3	5.2	2.2	1.9
ХАА-н газрууд	56.8	0.8	29.0	0.8	2.1	0.1
цэвэр	36.9	0.5	19.5	0.6	0.0	0.1
эрлийз	19.9	0.3	9.5	0.2	2.1	0.0

1998 онд цэвэр үүлдрийн хээлтэгч 395.4 мянга, эрлийз үүлдрийн 595.8 мянган хээлтэгч мал тоологдов. Цэвэр үүлдрийн болон эрлийз малд үнээ 52.4 хувь, эм хонь 51.7 хувь, эм ямаа 55.8 хувийг эзлэж байна.

Цэвэр үүлдрийн болон эрлийз хээлтэгч малын тоо (мян.тол)

	1995	1996	1997	1998	1998\1997	
					Хувь	Зөрүү
1.Цэвэр үүлдрийн бүх мал	375.4	358.6	361.9	395.4	109.3	33.5
Үнээ	22.3	22.8	20.7	20.2	97.6	-0.5
Эм хонь	312.9	297.5	296.7	332.1	111.9	35.4
Эм ямаа	40.2	38.3	44.5	43.1	96.9	-1.4
2.Эрлийз үүлдрийн	425.9	449.6	524.9	595.8	113.5	70.9
Үнээ	47.7	45.5	49.2	63.1	128.3	13.9
Эм хонь	288.2	314.9	378.0	409.2	108.3	31.2
Эм ямаа	90.0	89.2	97.7	123.5	126.4	25.8

Цэвэр үүлдрийн болон эрлийз малын хээлтэгчийн эзлэх хувь

	Үхэр		Хонь		Ямаа	
	1997	1998	1997	1998	1997	1998
Бүгд	39.7	52.4	49.5	51.7	45.7	55.8
цэвэр	41.3	50.8	48.5	52.0	48.7	51.2
эрлийз	39.1	52.9	50.3	51.5	44.4	57.6
Хувийн аж ахуй	38.7	53.3	48.3	51.3	45.5	55.8
цэвэр	40.3	56.6	46.0	51.8	48.3	50.1
эрлийз	38.3	52.6	50.0	51.0	44.4	57.7
ХАА-н газрууд	43.9	48.3	56.9	55.9	44.8	56.3
цэвэр	42.4	43.6	58.9	53.1	-	57.9
эрлийз	46.8	56.1	52.8	63.3	44.8	52.2

II.2. Тэжээвэр амьтад.

1998 оны эцэст 20.0 мянган гахай, 66.6 мянган шувуу, 643 цаа буга, 1510 илжиг, 1057 бүл зөгий тоологдов. 1997 оныхоос гахайн тоо 0.9 мянгаар буурч, шувууны тоо 1.5 мянгаар өссөн байна.

Тэжээвэр амьтад, тэдгээрийг өсгөж, үржүүлдэг өрх, аж ахуйн тоо

	1990	1995	1996	1997	1998	1998\1997
Гахай (мян.тол)	134.7	23.5	19.1	20.8	19.9	95.5
Шувуу (мян.тол)	326.2	99.3	58.0	65.1	66.6	102.3
Цаа буга	3231	900	668	619	643	103.9
Илжиг, луус	1018	913	1064	953	1510	158.3
Зөгий бүл	4768	1165	1075	977	1057	108.2
Туулай	7179	118	122	105	193	183.8
Үнэг	1251	568	180	50	28	56.0
Булга	9691	180	-	-	-	-
Гахайтай өрхийн тоо (мян)	15.7	4.2	3.4	2.9	2.9	102.6
Шувуутай өрхийн тоо (мян)	1.3	2.2	1.6	2.1	3.4	164.9

Нийт гахайн тоо 1997 оныхоос 10 аймаг, хотод өссөний дотор Баянхонгор, Завхан аймагт 2.8-7.0 дахин, Булган, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Увс, Хөвсгөл, Хэнтий, Орхон аймагт 3.9-91.1 хувиар өсчээ.

Шувууны тоо 11 аймаг, хотод өссөн байна. (Хавсралтын хуудасны дугаар 27– 29)

1998 онд аминдаа гахайтай өрх 2.9 мянга, шувуутай өрх 3.4 мянга болсон нь 1997 оныхоос гахайтай өрх 75-аар өсч, шувуутай өрх 1339-р өссөн байна. Одоо нийт гахайны 84.5 хувь, шувууны 20.7 хувь хувийн аж ахуйд байна.

Гахай, шувууны тоо, өмчийн төрлөөр (мян.тол)

	Гахай				Үндсэн мэгж			
	1997	1998	1998\1997 хувь	Хувийн жин	1997	1998	1998\1997 хувь	Хувийн Жин
Дүн	20.8	20.0	95.5	100.0	5.6	5.6	98.6	100.0
Үүнээс: хувийн АА	17.0	16.8	99.0	84.5	5.1	5.0	99.4	90.1

	үргэлжлэл							
	Шувуу				Өндөглөгч			
	1997	1998	1998\1997 хувь	Хувийн жин	1997	1998	1998\1997 хувь	Хувийн Жин
Дүн	65.1	66.6	102.3	100.0	59.6	60.5	101.5	100.0
Үүнээс: хувийн АА	20.2	13.8	68.1	20.7	14.8	9.5	64.0	16.0

II.3. Малын бэлчээр, тэжээлийн хүрэлцээ, хангамж

Бэлчээрийн хүрэлцээ. Газар зохион байгуулах албаны 1998 оны тайлангаар манай улсын бэлчээр, хадлангийн талбайг 127.8 сая га гэж тогтоосон нь 1990 оныхоос 2.8 хувь буюу 3.5 сая гагаар нэмэгджээ. Энэ хугацаанд малын тоо хонин толгойд шилжүүлснээр 70.2 сая болж 28.6 хувь буюу 15.6 сая толгойгоор өссөн байна.

Малын тоо толгой өссөнтэй холбогдон 100 га бэлчээр, хадлангийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо 1989 онд 43 байсан бол 1997 онд 53, 1998 онд 55 болж нэмэгдэв.

Одоо 100 га бэлчээр, хадлангийн талбайд Орхон аймагт 726 толгой, Улаанбаатар хотод 247 толгой, Дархан-Уул, Булган, Архангай, Хөвсгөл аймагт 108-203 толгой (хонин толгойд шилжүүлсэн) мал ногдож байгаа нь аймгууд дотроос бэлчээрийн ачааллын хувьд хамгийн өндөр үзүүлэлт болж байна.

Өнгөрсөн есөн жилд ихэнх аймгийн бэлчээрт ногдох мал нэмэгдсэний дотор бэлчээрийн хүрэлцээ Орхон, Дархан-Уул, Төв аймагт 1.7-3.3 дахин багасчээ. Харин 1989 оноос Дорнод аймгийн мал хорогдсон, Улаанбаатарт бэлчээр нэмэгдснээс 100 га бэлчээр хадлангийн талбайд ногдох малын тоо буурсан байна.

Бэлчээрийн хүрэлцээ, аймаг, нийслэлээр

	Хадлан, бэлчээрийн талбай (мян.га)			100 га хадлан, бэлчээрийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо			1998\1989 хувь
	1989	1993	1998	1989	1993	1998	
АР	4536.3	4541.7	4255.0	85	89	137	161.5
БӨ	4178.6	4178.7	4412.6	56	43	54	96.7
БХ	9067.0	9067.0	11024.8	31	33	41	130.8
БУ	3173.1	3178.3	2952.0	79	85	130	164.7
ГО	8924.2	9491.4	12152.6	30	28	26	88.2
ДО	10592.4	10132.7	10249.3	20	17	22	109.4
ДД	9967.3	9966.9	10460.0	21	19	19	90.4
ДУ	7392.3	7377.9	7365.9	39	38	58	147.6
ЗА	6854.5	6855.7	6736.8	56	56	77	138.2
ӨВ	5982.9	5982.8	5917.7	68	72	101	148.9
ӨМ	14597.8	14597.7	12231.6	14	12	23	163.0
СҮ	6873.3	6876.6	8156.3	35	39	40	113.7

СЭ	1959.7	1946.0	1574.8	57	57	85	149.4
ТӨ	6040.7	5828.4	5152.3	62	65	104	167.1
УВ	5684.4	5684.2	5578.0	59	54	66	111.1
ХО	5995.5	5995.1	6585.3	50	52	48	96.6
ХӨ	5629.1	5355.3	5499.6	76	81	108	142.5
ХЭ	6405.8	6290.5	6412.3	50	45	56	111.2
ДА	190.2	190.2	193.4	110	165	203	184.8
УБ	58.2	58.2	292.8	691	1155	247	35.7
ОР	53.6	53.5	43.3	222	478	726	327.0
ГС	-	459.7	538.6	-	41	52	-
ДҮН	124156.9	124108.5	127785.0	43	43	55	127.8

Малын тэжээлийн үйлдвэрлэлт, хангамж. 1998 онд улсын хэмжээгээр 330.3 мянган тонн тэжээлийн нэгжтэй тэнцэх хэмжээний тэжээл үйлдвэрлэсэн нь 1997 оныхоос 2.9 хувь буюу 9.9 мянган тонноор буурчээ..

Үйлдвэрлэсэн тэжээлийг нэр төрлөөр нь авч үзвэл өнгөрсөн оныхоос багсармал, эрдэс болон гар тэжээлийн хэмжээ 22.7-79.6 хувиар нэмэгдэж, ногоон тэжээл, бэлтгэсэн дарш 23.3-31.2 хувиар багассан байна.

Тэжээл үйлдвэрлэлийн хэмжээ (тэжээлийн нэгжид шилжүүлснээр) 12 аймагт буурсны дотор Дундговь, Өмнөговь, Улаанбаатар, Төв аймагт 35.7-51.5 хувиар багасчээ.

1998 онд улсын хэмжээгээр 667.0 мянган тонн байгалийн хадлан бэлтгэсэн нь өнгөрсөн оныхоос 0.6 мянган тонн буюу 0.1 хувь буурчээ. Дундговь, Өмнөговь, Төв, Сүхбаатар зэрэг 12 аймагт бэлтгэсэн өвсний хэмжээ өмнөх оныхоос буурсан байна. (Хавсралтын хуудасны дугаар 30-34)

Тэжээлийн хэмжээг нэр төрлөөр үзүүлбэл : (мян.т)

	1986\1990 дундаж	1991\1995 дундаж	1996	1997	1998	1998\1997 хувь
Байгалийн хадлан	1154.2	733.7	701.3	667.7	667.0	99.9
Сүрэл	114.1	47.2	21.9	16.3	16.0	98.2
Ногоон тэжээл	255.6	23.9	1.6	3.2	2.2	68.8
Олон наст өвс	21.8	4.7	0.8	0.3	0.3	100.0
Гар тэжээл (тэж.нэгж)	21.7	9.6	9.8	11.3	20.3	179.6
Багсармал тэжээл	139.8	17.5	4.8	4.4	5.4	122.7
Бэлтгэсэн дарш	277.7	66.2	10.4	10.3	7.9	76.7
Эрдэс тэжээл	61.9	18.1	18.3	19.4	26.2	135.1
Үйлдвэрлэсэн тэжээл бүгд(тэж.нэгж)	999.4	437.9	349.2	340.2	330.3	97.1

Сүүлийн жилүүдэд нийт тэжээлд хүчит болон шүүст тэжээлийн эзлэх хувийн жин буурч байна.

Үйлдвэрлэсэн тэжээлийн бүтэц, тэжээлийн хангамж

	1993	1994	1995	1996	1997	1998
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
хүчит	15.3	9.5	7.4	3.3	4.2	1.6
шүүст	3.9	2.2	1.8	1.4	2.1	0.6
бүдүүн	80.8	88.3	87.4	92.5	90.0	91.7
бусад	-	-	3.4	2.8	3.7	6.1
Хонин толгойд шилжүүлсэн нэг малд ногдох тэжээл (тэж.нэгж,кг)	7.8	6.5	7.1	5.5	4.9	4.7

1998 оны байдлаар хонин толгойд шилжүүлсэн нэг малд ногдох тэжээл 1997 оныхоос 0.2 кг-аар багасч, тэжээлийн нэгжээр 4.7 кг тэжээл ногдож байгаа нь нийт малыг 2.4 хоног тэжээх нөөцтэй гэсэн үг юм.

III. Малчдын тоо, тэдний орлого

III.1. Малчдын тоо, насны бүлэг. 1998 оны жилийн эцсийн мал тооллогоор улсын хэмжээгээр 187.1 мянган малчин өрхөд 414.4 мянган малчид байна. Малчдын тоо өмнөх оныхоос 1.2 хувь буюу 4.8 мянгаар нэмэгдэв.

Нийт малчдын 55.8 хувь нь 16-34 насны залуучууд, 30.3 хувь нь 35-аас тэтгэвэрт гарах хүртлэх насны хүмүүс байна.

Малчдын дотор залуучуудын тоо нэмэгдэн, тэтгэвэрийн насны хүмүүсийн хувийн жин буурч, 1997 онд 15.2 хувь байсан бол 1998 онд 13.9 хувь болжээ.

Өрх, малчдын тоо, бүрэлдэхүүн

	1994	1995	1996	1997	1998	1998\1997 хувь
Малчин өрх (мян)	167.3	169.3	170.1	183.6	187.1	101.9
Малчдын тоо (мян)	377.1	390.5	395.4	409.6	414.4	101.2
Үүнээс: 16-34 насны	204.8	225.2	226.5	223.9	231.3	103.3
35-аас тэтгэвэрт гарах хүртэл насны	106.3	95.4	109.2	123.4	125.4	101.6

Тэтгэврийн насны	66.0	69.9	59.7	62.3	57.7	92.6
Насны бүрэлдэхүүн (хувиар)	100.0	100.0	100.0	100.0	100.0	
Үүнээс:16-34 насны	54.3	57.7	57.3	54.7	55.8	
35-аас тэтгэвэрт гарах хүртэл насны	28.2	24.4	27.6	30.1	30.3	
Тэтгэврийн насны	17.5	17.9	15.1	15.2	13.9	
Нэг малчин өрхөд ногдох малын тоо* (тол)	160	169	172	170	176	103.5

* Нийт малд оногдуулж бодсоноор

1997 онд нэг малчин өрхөд улсын дунджаар 170 толгой мал ногдож байсан бол 1998 онд 176 толгой болов.

Архангай, Хөвсгөл, Дархан-Уул, Орхон, Өвөрхангай аймгийн нэг малчин өрхөд 113-137 толгой мал ногдож байхад Сэлэнгэ, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр, Өмнөговь, Говь-Алтай аймагт 217-257 толгой мал ногдож байна. (Хавсралт хүснэгтийн 34-р хуудаснаас үзнэ үү. Цаашид хавсралт хүснэгтийн хуудасны дугаарыг заана)

III. 2. Малчин өрхийн орлого. 1998 оны жилийн эцсийн мал тооллоготой хамтруулан малчин өрхийн 5.0 хувь буюу 9.2 мянган өрхөд мал аж ахуйн бүтээгдэхүүний борлуулалтын орлогын хэмжээг тодорхойлох түүвэр судалгааг явуулав.

Судалгааний зорилго нь малчин өрхийн мал аж ахуйн бүтээгдэхүүнээс гадгаш худалдан борлуулсан орлогын хэмжээг малын тоо толгойн бүлэглэлтэй холбон судлах, нэг өрхийн орлогын дундаж хэмжээг сум, аймаг, улсын түвшинд тодорхойлох явдал байв. Малчин өрхийн орлогын хэмжээг тодорхойлохдоо өрхийн аж ахуйн дотоодын хэрэглээг тооцож оруулах зорилт тавиагүй болно.

Түүвэр судалгаанд хамрагдсан 9.2 мянган өрхийн дүнгээр нэг малчин өрх дунджаар 4.8 ам бүлтэй, 210 толгой малтай, жилдээ 500.2 мянган төгрөг, сард 41.7 мянган төгрөгийн орлоготой байна.

Судалгааны дүнгээс үзвэл 10 хүртэл малтай малчин өрхийн жилийн дундаж орлого 63.2 мянган төгрөг байхад 2000-аас дээш малтай өрхийн жилийн дундаж орлого 4.5 сая төгрөг болж байна. Малчдын дотроос бизнесийн хүрээнд хамгийн жин, нөлөөтэй хэсэг нь 51-ээс дээш малтай өрхүүд бөгөөд эдгээр нь нийт өрхийн 70 хувь, малын 90 гаруй хувийг эзлэж байна. Гэтэл малчин өрхийн 30 шахам хувийг эзлэж байгаа ядуулаг хэсэг нь болох 50 хүртэл малтай өрхүүдэд малын дөнгөж 3.8 хувь ногдож байна.

10 хүртэл малтай өрхийн нэг ам бүлд дунджаар 2 толгой мал ногдож байгаа бөгөөд сарын дундаж орлого нь 1285 төгрөг, 11-30 малтай өрхийн нэг ам бүлд 5 толгой мал, сарын дундаж орлого нь 2145 төгрөг болж байна.

Судалгаанд хамрагдсан малчин өрхийн мал, орлогын бүлэглэлт

	Судлагдсан өрхийн тоо	Нэг өрхөд дундажаар ногдох				Нэг ам бүлд ногдох	
		малын тоо		Орлого (мян.төг)		малын тоо	сарын орлого (мян.төг)
		1997	1998	1997	1998		
10хүртэл малтай	638	7	7	71.0	63.2	2	1285
11-30-“-	985	22	22	121.7	110.7	5	2145
31-50-“-	1127	41	42	194.2	172.6	10	3345
51-100-“-	1802	77	76	302.8	248.1	17	4594
101-200	1934	148	150	434.7	413.6	31	7180
201-500	1657	326	328	716.0	744.4	61	11488
501-999	711	666	657	1227.1	1298.6	110	18036
1000-1499-“-	281	1125	1138	2107.0	2285.7	181	30234
1500-2000-“-	36	1651	1629	3475.4	3505.8	264	47121
2001-ээс дээш-“-	18	2403	2312	4215.3	4464.8	385	62011
ДҮН	9189	164	210	421.0	500.2	44	8684

Өрхийн орлогын дүнд мал, мах борлуулсны орлого 47.9 хувь, ноос, ноолуур, хөөвөр, хялгасны орлого 30.4 хувь, арьс, ширний орлого 10.6 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүний орлого 7.1 хувийг эзлэж байна. Сүүлийн жилүүдэд өрхийн мал, мах, ноос, ноолуурын борлуулалтаас олсон орлогын хувийн жин нэмэгдэж иржээ.

Өрхөд оруулж байгаа орлогын хэмжээгээрээ ямааны аж ахуй нэгдүгээрт, хонины аж ахуй хоёрдугаарт, үхрийн аж ахуй гуравдугаарт орж байна. Мал аж ахуйгаас орсон орлогын 33.5 хувийг ямааны аж ахуй, 30.2 хувийг хонины, 21.2 хувийг үхрийн, 8.5 хувийг адууны, 2.6 хувийг тэмээний аж ахуй бүрдүүлж байна.

Малчин өрхийн орлого, орлогын бүрэлдэхүүн

	Борлуулалтын орлогын бүтэц, бүрэлдэхүүн (хувь)		
	1996	1997	1998
Орлого, бүтээгдэхүүний төрлөөр :			
Мах, махны борлуулалтын орлого	43.9	45.8	47.9
Сүү, сүүн бүтээгдэхүүний орлого	6.2	9.0	7.1
Ноос, ноолуур, хөөвөр, хялгасны орлого	26.8	29.3	30.4
Арьс ширний орлого	20.7	13.3	10.6
Бусад орлого	2.4	2.6	4.0

ДҮН	100.0	100.0	100.0
Орлого, мал аж ахуйн төрлөөр			
Тэмээний аж ахуйгаас	2.8	3.1	2.7
Адууны аж ахуйгаас	7.9	9.5	8.9
Үхрийн аж ахуйгаас	21.0	23.2	22.1
Хонины аж ахуйгаас	37.0	31.2	31.5
Ямааны аж ахуйгаас	31.3	33.0	34.8

Тэмээний аж ахуйд мал, мах борлуулалт орлогын эзлэх хувийн жин урьд жилүүдийнхээс буурч, ноосных өссөн нь нааштай үзүүлэлт болов. Сүүлийн жилүүдэд тэмээний аж ахуйд мал, махны борлуулалт анхдагч орлого болж байсан хандлага 1998 онд өөрчлөгдөж, ноосны орлого тэргүүлэх болжээ. Энэ байдал тэмээний тоо толгойн өсөлтөд нөлөөлсөн байна.

Тэмээний аж ахуйн бүтээгдэхүүний орлогын бүтэц (хувиар)

	1996	1997	1998
Мал, махны борлуулалтын орлого	49.9	51.0	44.7
Сүү, сүүн бүтээгдэхүүний орлого	2.9	2.4	3.5
Ноосны орлого	45.0	44.4	49.2
Арьс, ширний орлого	2.2	2.2	2.6
ДҮН	100.0	100.0	100.0

Адуу, үхрийн аж ахуйд мал, мах борлуулалтын орлогын эзлэх хувийн жин зонхилж, сүүний орлого удаалж байна. Судалгаанаас үзэхэд зах зээлээс хол байгаа малчин өрхүүдэд илүүдэл сүү, айргаа борлуулах боломж бараг байдаггүй байна.

1998 оны байдлаар нийт адууны 23.8 хувь, үхрийн 29.5 хувийг хөөвөрлөж, 18.2-43.0 хувиас хялгасыг нь авч ашигласан дүн гарав. Малчдын өөрийн хэрэгцээ хязгаартай, орон нутагт нийлүүлэх зах зээл хомс тул бод малын хөөвөр, хялгас авч ашиглах хэмжээ эрс багасчээ. Иймд адуу, үхрийн аж ахуйд хөөвөр, хялгасны орлого нэмэгдүүлэх боломж хязгаарлагдмал байна.

Адуу, үхрийн аж ахуйн бүтээгдэхүүний орлогын бүтэц (хувиар)

	Адууны аж ахуй		Үхрийн аж ахуй	
	1997	1998	1997	1998
Мах, махны бүтээгдэхүүний орлого	70.2	72.0	64.4	71.0
Сүү, сүүн бүтээгдэхүүний орлого	20.0	20.3	26.3	21.1
Хөөвөр, хялгасны орлого	1.6	1.0	1.4	0.8
Арьс, ширний орлого	8.2	6.7	7.9	7.1
ДҮН	100.0	100.0	100.0	100.0

Хонь, ямааны аж ахуй. Хонины аж ахуйд мал, мах борлуулалтын орлого нэмэгдэж, зонхилох байртай байна. Энэ нь хөдөөд хонь солилцооны түгээмэл хэргэслэлийн үүрэг гүйцэтгэсэн хэвээр байгааг гэрчилж байна. Ноосны орлогын хувийн жин нэмэгдэхгүй байгаа нь ашиг шимийн гарцын хэмжээ буурсантай бас холбоотой юм.

Ямааны аж ахуйн орлогын дөрөвний гурвыг ноолуурын орлого бүрдүүлж байна. Үүнтэй холбогдон ямааг махны хэрэгцээнд борлуулах явдал зах зээлийн хуулиар журамлагдан, нийт орлогод 15 хувиас огт хэтрэхгүй болов.

Хонь, ямааны аж ахуйн бүтээгдэхүүний орлогын бүтэц (хувиар)

	Хонины аж ахуй		Ямааны аж ахуй	
	1997	1998	1997	1998
Мах, махны бүтээгдэхүүний орлого	60.4	67.7	15.2	15.2
Сүү, сүүн бүтээгдэхүүний орлого	1.4	0.8	2.0	1.7
Хөөвөр, хялгасны орлого	13.6	11.8	73.0	75.8
Арьс, ширний орлого	24.6	19.7	9.8	7.3
ДҮН	100.0	100.0	100.0	100.0

Малчин өрхийн аж ахуйд малын төрөл тус бүрийн орлогын хэмжээ байгалийн бүс нутгаар нилээд ялгавартай байна. Хангай тал, хээрийн бүсийн аймгуудын өрхийн орлогод үхэр, хонь, адууны аж ахуйн бүтээгдэхүүн зонхилж байхад говь, Их нуурын хотгорын бүсийн аймгуудад ямаа, хонь, тэмээний аж ахуйн бүтээгдэхүүн голлох байрыг эзлэж байгаа билээ.

Судалгаанаас үзвэл сүүлийн жилүүдэд Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотуудын малтай өрхүүдээс зах зээлд нийлүүлсэн айраг, адууны махны борлуулалт нэмэгдэж байна.

Хангай, тал хээрийн бүсийн аймгийн малчин өрхийн орлогод голлох суурийг эзэлдэг мал аж ахуйн төрөл (хувиар)

	Үхрийн аж ахуйн орлого		Хонины аж ахуйн орлого		Адууны аж ахуй орлого	
	1997	1998	1997	1998	1997	1998
Архангай	33.8	31.0	29.0	28.1	17.1	13.5
Булган	32.7	26.0	28.3	37.5	16.0	18.9
Дорнод	39.0	31.9	36.4	45.3	7.8	6.9
Завхан	20.3	18.5	37.4	40.5	8.2	8.6
Өвөрхангай	19.6	19.6	31.2	32.4	9.7	9.4
Сүхбаатар	26.0	28.0	32.4	30.4	8.4	11.5
Сэлэнгэ	45.7	43.1	21.8	27.2	8.5	11.3
Төв	33.0	26.3	31.8	34.5	16.8	15.1
Хөвсгөл	30.5	33.9	31.8	28.8	8.6	6.6
Хэнтий	41.3	35.1	24.7	25.9	12.3	6.7
Дархан-Уул	40.6	28.9	32.6	19.1	8.4	41.3
Улаанбаатар	47.6	51.7	21.7	15.8	16.3	12.4
Орхон	45.9	39.6	30.7	10.9	11.4	37.3
Говьсүмбэр	36.1	16.3	32.2	27.6	11.4	10.1

Хонины аж ахуй байгалын аль ч бүсэд гэсэн ач холбогдол ихтэй, таваарлаг салбар болж байна. Судалгаанд хамрагдсан өрхийн борлуулалтын орлогын хэмжээгээр нь авч үзвэл Завхан, Дорнод, Баян-Өлгий зэрэг 6 аймагт хонины аж ахуй, Өмнөговь, Баянхонгор, Дундговь зэрэг 9 аймагт ямааны аж ахуй, Сэлэнгэ, Хөвсгөл, Хэнтий зэрэг 7 аймаг, хотод үхрийн аж ахуй тэргүүлэх үүрэгтэй байна.

Говь, Их нуурын хотгорын бүсийн аймгийн малчин өрхийн орлогод
голлох суурийг эзэлдэг мал аж ахуйн төрөл (хувиар)

	Ямааны аж ахуйн орлого		Хонины аж ахуйн орлого		Тэмээний аж ахуйн орлого	
	1997	1998	1997	1998	1997	1998
Баянхонгор	50.8	48.1	22.9	24.6	4.4	3.1
Говь-Алтай	46.0	48.4	39.9	33.4	3.3	3.4
Дорноговь	40.5	32.7	28.8	27.0	6.3	7.4
Дундговь	37.6	44.0	37.3	30.6	5.1	3.7
Өмнөговь	64.4	63.8	9.2	13.0	17.4	15.4
Ховд	38.3	42.0	28.9	26.4	3.3	3.1
Увс	29.4	35.1	31.8	29.5	3.9	4.4
Баян-Өлгий	28.9	28.9	29.2	38.3	2.6	2.5

Судалгаагаар төвийн болон говийн бүс аймгуудын өрхийн дундаж орлого улсын дунджаас дээгүүр байна. Энэ нь нэгдүгээрт эдгээр аймгийн зах зээлийн орчин нөхцөлтэй, хоёрдугаарт нэг өрхөд ногдох малын тоо, бүрэлдэхүүнтэй холбоотой байна.

Орхон, Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн өрхийн аж ахуйд үнээний сүү, мал, махны борлуулалтын орлого голлох үүрэгтэй байна.

1998 онд судалгаанд хамрагдсан малчин өрхүүдийн жилийн
дундаж орлогын хэмжээгээр аймгуудыг байр эзлүүлбэл

	Судлагдсан өрхийн тоо	Өрхийн дундаж	
		орлого (мян.төг)	малын тоо
1.Орхон	44	1361.1	101
2.Сэлэнгэ	119	824.4	244
3.Өмнөговь	327	753.1	303
4.Дундговь	394	752.9	315
5.Завхан	673	736.7	258
6.Төв	476	669.4	277
7.Дорноговь	189	628.5	241
8.Дархан-Уул	51	625.4	160
9.Говьсүмбэр	25	591.8	400
10.Хэнтий	355	587.7	284
11.Говь-Алтай	491	587.5	260
12.Баянхонгор	696	577.0	250
13.Ховд	510	542.0	220
14.Дорнод	224	536.8	263
15.Улаанбаатар	102	466.9	95
16.Сүхбаатар	344	457.7	173
17.Увс	592	422.4	201
18.Өвөрхангай	982	386.0	170
19.Булган	367	358.3	179
20.Баян-Өлгий	477	317.8	131
21.Хөвсгөл	896	292.4	124
22.Архангай	855	282.2	161
Улсын дундаж	9189	500.2	210

ДҮГНЭЛТ, САНАЛ

1998 онд манай улсын мал сүргийн тоо таван төрөл дээр өсч, 32.9 сая толгойд хүрсэн нь урьд өмнө үзэгдээгүй тоо хэмжээ юм. Сүүлийн гурван жилд тэмээний тоо анх удаа өсч, хонины тоо хагас сая илүүтэй нэмэгдсэн нь тэмдэглүүштэй зүйл болов.

1990 оныхоос нийт малын тоо 7.0 сая толгойгоор өссөний дотор ямааны тоо 5.9 сая, үхэр 0.9 сая, адуу 0.8 сая, хонины тоо 0.4 сая, тэмээний тоо 0.2 саяар буурсан дүнтэй байна.

Өнгөрсөн найман жилд таван төрлийн малын харьцаанд болон дотоод бүтцэд томоохон өөрчлөлт гарлаа. Үхэр, бог малын дотор, эр малын эзлэх хувийн жин мэдэгдэхүйц нэмэгдсэн нь, сүргийн бүтцийг сайжруулсан өөрчлөлт юм. Харин малын тоо толгойн өсөлтийн дийлэнх ямааны өсөлтөөр хангагдаж, одоо нийт малын гуравны нэг нь ямаа болоод байна. Энэ нь ямааны аж ахуй өрхийн орлогод тэргүүлэх байр эзэлж, харьцангуй ашигтай байгаатай холбоотой. Цаашид ч ямааны тоо өсөх төлөвтэй байна.

Мал өссөнтэй холбогдон сүүлийн найман жилд бэлчээрийн даацын ачаалал 1.3 дахин нэмэгдсэн байна. Орхон, Дархан-Уул аймаг, Улаанбаатар хот, өндөр уулын болон хангайн бүсийн зарим сумдад бэлчээрийн хомсдол бодит зүйл боллоо. Манай эрдэмтэд бэлчээрийн даацыг хонин толгойд шилжүүлсэн 60.0 сая мал гэж тооцоолсон бол одоо 70.0 сая мал болоод байна. Гэвч бэлчээрийн даацын асуудал нэлээд харьцангуй ойлголт бөгөөд хамгийн гол нь цаг агаар, зуншлага, цас зудаас их хамаарах юм.

Мал өсч, сүргийн бүтэц сайжирсантай холбогдон манай улсын мах экспортлох боломж ихээхэн нэмэгдэв. Малын тоо толгойн жилийн дундаж хэмжээ 23.0 сая байсан 1961-1987 онуудад жилд дунджаар 137.2 мянган тонн амьдын жин бүхий мал, мах гадаадад гаргаж байжээ. Энэ бол жилдээ 2.2 сая мал экспортод гаргаж байсан гэсэн үг юм. Мал, мах экспортод нийлүүлсэн оргил үе болох 1979-1980 онд 165-167 тонн амьдын жинд хүрч, 2.5-2.6 сая мал зарцуулагдаж байсан байна. (Хавсралт хүснэгтийн 37-р хуудас)

Манай улс махны балансын нийт үйлдвэрлэлийнхээ гуравны хоёрыг дотооддоо хэрэглэж, гуравны нэгийг гадаадад гаргаж байв. Экспортын ийм их үүрэг хүлээдэг байсан учраас мал өсгөх боломж нэн хязгаарлагдмал болж, сүргийн бүтэц ихээхэн алдагдаж, эр малын нөөцгүй шахам болсон сөрөг үзэгдэл гарсан билээ.

Урьд нь малыг хэр хэмжээнээсээ хэтрүүлэн экспортолдог байсан бол одоо бараг мах экспортлохгүй шахам болчихоод байна. Өнгөрсөн зургаан жилийн гүйцэтгэлээс үзвэл жилд дунджаар 5.5 мянган тонн мах экспортолсныг амьдын жинд шилжүүлэн тооцвол 11.0 мянга орчим тонн болох бөгөөд энэ нь урьд гадаадад гаргаж байсан хэмжээний арван хувьд ч хүрэхгүй байна.

Монгол улс мал аж ахуйн орон тул мал экспортлох явдлыг зохистой хэмжээнд байлгах шаардлагатай. Цаашдаа жилд амьдын жингээр 50.0-60.0 мянган тонн буюу 900 мянгаас 1 сая орчим толгой малын мах экспортлох, үүний 40 хувь нь үхрийн мах, 30 хувь хонины, 20 хувь нь ямааны, 10 хувь нь адууны мах байж болох юм.

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН
ГАЗРЫН ДЭД ДАРГА.....Б.Батмөнх

1999.03.01

**Мал сүргийн тоогоор улсад эхний таван байрт
орох аймаг, аймаг, сумд, 1998 оны тооллогоор**

Аймгийн нэр	Малын тоо (мян.тол)	Сумын нэр	Малын тоо (мян.тол)
Нийт малын тоогоор			
1.Өвөрхангай	2921.5	1.Дундговийн Эрдэнэдалай	347.0
2.Завхан	2603.6	2.Өвөрхангайн Баянгол	263.3
3.Баянхонгор	2511.3	3.Өвөрхангайн Богд	260.2
4.Хөвсгөл	2295.9	4.Хөвсгөлийн Цагаан-Уул	223.2
5.Төв	2238.5	5.Баянхонгорийн Бууцагаан	222.8
Тэмээгээр			
1.Өмнөговь	97.7	1.Өмнөговийн Мандал-Овоо	14.1
2.Баянхонгор	38.7	2.Өмнөговийн Ханбогд	13.4
3.Говь-Алтай	35.3	3.Баянхонгорын Баянлиг	10.6
4.Дорноговь	29.5	4.Өмнөговийн Гурвантэс	9.2
5.Дундговь	29.4	5.Дундговийн Өлзийт	8.3
Адуугаар			
1.Төв	302.7	1.Дундговийн Эрдэнэдалай	36.6
2.Өвөрхангай	279.1	2.Булганы Сайхан	29.5
3.Архангай	271.6	3.Өвөрхангайн Баян-Өндөр	27.5
4.Хөвсгөл	235.6	4.Төв аймгийн Бүрэн	27.0
5.Дундговь	218.0	5.Архангайн Хотонт	25.6
Үхрээр			
1.Хөвсгөл	458.5	1.Өвөрхангайн Уянга	45.7
2.Архангай	428.1	2.Архангайн Тариат	38.7
3.Өвөрхангай	282.4	3.Хөвсгөлийн Цагаан-Уул	34.6
4.Завхан	281.9	4.Архангайн Өндөр-Улаан	34.2
5.Төв	263.5	5.Хөвсгөлийн Цэцэрлэг	33.2
Хониор			
1.Өвөрхангай	1387.9	1.Дундговийн Эрдэнэдалай	165.4
2.Завхан	1353.7	2.Өвөрхангайн Баянгол	150.6
3.Төв	1172.6	3.Өвөрхангайн Сант	110.3
4.Увс	983.2	4.Хөвсгөлийн Цагаан-Уул	106.7
5.Дундговь	971.5	5.Өвөрхангайн Баян-Өндөр	102.7
Ямаагаар			
1.Баянхонгор	1252.3	1.Өвөрхангайн Богд	164.7
2.Говь-Алтай	1029.0	2.Баянхонгорын Бууцагаан	128.6
3.Өвөрхангай	952.6	3.Өмнөговийн Гурвантэс	128.0
4.Өмнөговь	923.7	4.Баянхонгорийн Баянцагаан	117.2
5.Дундговь	856.5	5.Баянхонгорийн Баацагаан	115.4

1000-аас дээш малтай өрхийн тоо, аймаг, нийслэлээр, 1998 оны байдлаар

Аймаг	Бүгд	Ү ү н э э с		
		1000-1499 малтай	1500-2000 малтай	2001-ээс дээш малтай
Архангай	49	41	4	4
Баян-Өлгий	5	5	-	-

Баянхонгор	96	87	6	3
Булган	73	67	2	4
Говь-Алтай	59	53	2	4
Дорноговь	19	18	1	-
Дорнод	27	24	3	-
Дундговь	103	98	5	-
Завхан	91	79	8	4
Өвөрхангай	47	40	3	4
Өмнөговь	36	34	1	1
Сүхбаатар	52	48	1	3
Сэлэнгэ	15	13	2	-
Төв	101	94	6	1
Увс	41	35	3	3
Ховд	39	37	2	-
Хөвсгөл	23	19	3	1
Хэнтий	67	58	8	1
Дархан-Уул	3	3	-	-
Улаанбаатар	3	3	-	-
Орхон	-	-	-	-
Говьсүмбэр	6	4	2	-
ДҮН	955	860	62	33